

Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: “ЛэндМН ББСБ” ХК УБГД: 000333641 Үнэт цаасны код: MN0LEND05453 Утасны дугаар: 77070101
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	“Монголын Хөрөнгийн Бирж” ХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Санхүүгийн салбар – Банк Бус Санхүүгийн Салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	800,000,000 ширхэг (эргэлтэд 739,301,683 ширхэг)
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Жилийн тайланг бэлтгэсэн: Хуулийн мэргэжилтэн М.Маралмаа Жилийн тайланг хянасан: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Х.Хулан

1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
----	---

	Санхүүгийн байдлын үзүүлэлт	2025 оны бүтэн жилийн санхүүгийн тайланг хавсаргав.			
		Санхүү байдлын тайлан /Нэгтгэсэн/:			
		Хөрөнгө /тэрбум төгрөг/	2023 /аудитлагдсан/	2024 /аудитлагдсан/	2025 /аудитлагдсан/
		Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	7.89	12.71	16.32
		Зээлийн багц (цэвэр)	123.46	231.73	307.71
		Бусад хөрөнгө	0.51	2.22	10.52
		Үндсэн хөрөнгө	1.25	4.94	4.25
		Биет бус хөрөнгө	0.36	0.75	1.38
		Нийт хөрөнгө	133.47	252.35	340.18
		Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/			
		Өр төлбөр	90.74	179.42	238.35
		Эх үүсвэр	79.29	167.09	216.49
		Хоёрдогч өглөг	2.95	2.95	13.63
		Бусад өглөг	8.50	9.38	8.23
		Эздийн өмчийн дүн	42.73	72.93	101.83
		Хувьцаат капитал	8.48	8.48	8.48
		Хуримтлагдсан ашиг	34.25	64.45	93.35
		Нийт өр төлбөр болон эздийн өмч	133.47	252.35	340.18
	Орлогын тайлан	Орлого, үр дүнгийн тайлан /Нэгтгэсэн/			
		Орлого, үр дүнгийн тайлан /тэрбум төгрөг/	2023 /аудитлагдсан /	2024 /аудитлагдсан /	2025 /аудитлагдсан /
		Хүүгийн орлого	47.84	89.19	135.40
		Хүүгийн зардал	(9.53)	(22.18)	(37.02)
		Цэвэр орлого	38.31	67.01	98.38
		Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(2.68)	(8.20)	(31.63)
		Үйл ажиллагааны цэвэр орлого	35.63	58.81	66.75
		Удирдлагын болон ҮА-ны зардал	(10.26)	(12.68)	(17.78)
		Татварын өмнөх ашиг	25.37	46.13	48.97
		Татварын зардал	(5.57)	(10.02)	(8.89)

		Үндсэн үйл ажиллагааны цэвэр ашиг	19.80	36.11	40.08	
		Татварын дараах алдагдал (Зогсоосон үйл ажиллагаа)	-	-	-	
		Цэвэр ашиг	19.80	36.11	40.08	
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Өмчийн өөрчлөлтийн тайлан:					
	Өмчийн өөрчлөлт ийн тайлан /тэрбум төгрөг/	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Бусад нөөц	Х.ашиг	Нийт эздийн өмч
	2023.12.31-ний өдрийн байдлаар	10.76	(2.34)	0.06	34.25	42.73
	Тайлан үеийн цэвэр ашиг				36.11	36.11
	Ногдол ашиг				(5.91)	(5.91)
	2024.12.31-ний өдрийн байдлаар	10.76	(2.34)	0.06	64.45	72.93
	Тайлан үеийн цэвэр ашиг				40.08	40.08
	Ногдол ашиг				(11.09)	(11.09)
	Охин компани татан буулгасантай холбоотой өөрчлөлт				(0.09)	(0.09)

		2025.12.31- ний өдрийн байдлаар	10.76	(2.34)	0.06	93.35	101.83
		Мөнгөн гүйлгээний тайлан /Нэгтгэсэн/:					
	Мөнгөн гүйлгээний тайлан	Мөнгөн гүйлгээний тайлан /тэрбум төгрөг/	2023 /аудитлагдсан/ н/	2024 /аудитлагдсан/ н/	2025 /аудитлагдсан/ /		
		Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(27.84)	(70.36)	(34.82)		
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	0.07	(2.84)	(1.43)		
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	30.44	78.02	39.86		
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/ өсөлт	2.67	4.82	3.61		
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5.22	7.89	12.71		
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7.89	12.71	16.32		
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт						

	2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн тайланд “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК нь хөндлөнгийн хараат бус аудитын дүгнэлтийг гаргасан ба уг дүгнэлтийг хавсаргав.	
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/	
	2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн тайланд “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК нь хөндлөнгийн хараат бус аудит хийж, дүгнэлт гаргасан тухай аудитын тодорхойлох захидлыг хавсаргав.	
2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд/	2025 оны санхүүгийн үзүүлэлтүүдийг өмнөх 2 жилийн мөн үетэй харьцуулсан байдал: Зээлийн багц /Тэрбум төгрөг/ 125.4 237.7 325.0 2023 2024 2025 +37% Хүүгийн орлого /Тэрбум төгрөг/ 47.8 89.2 135.4 2023 2024 2025 +52% Цэвэр ашиг /Тэрбум төгрөг/ 19.8 36.1 40.1 2023 2024 2025 +11% Нэгж хувьцаанд ногдох ашиг /Төгрөг/ 26.8 48.9 54.2 2023 2024 2025 +11%

		Зохистой харьцааны тайлан ЛэндМН нь зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 9 (IFRS 9) дагуу тооцдог. Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д заасны дагуу 2025 оны жилийн эцэст 13.2 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС 9 (IFRS 9)-н дагуу 28.6 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 114%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ. Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлаар Компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хэлэлцдэг бөгөөд 2025 онд зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.																																			
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<table><tr><th>Харьцаа үзүүлэлтүүд</th><th>Байвал зохих</th><th>2023</th><th>2024</th><th>2025</th></tr><tr><td>Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа</td><td>10%-иас доошгүй</td><td>27.7%</td><td>25.7%</td><td>27.0%</td></tr><tr><td>Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа</td><td>20%-иас доошгүй</td><td>29.6%</td><td>26.7%</td><td>30.6%</td></tr><tr><td>Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа</td><td>8%-иас дээш</td><td>11.2%</td><td>8.0%</td><td>16.4%</td></tr><tr><td>Гадаад актив, пассивын зөрүү, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа</td><td>(+/-40%)</td><td>- 39.5%</td><td>- 38.2%</td><td>-31.8%</td></tr><tr><td>Итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа</td><td>80%-иас хэтрэхгүй</td><td>79.7%</td><td>78.7%</td><td>57.3%</td></tr><tr><td>Өрийн бичгийн өглөг, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа</td><td>50%-иас хэтрэхгүй</td><td>26.5%</td><td>37.0%</td><td>18.1%</td></tr></table>	Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2023	2024	2025	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	27.7%	25.7%	27.0%	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	29.6%	26.7%	30.6%	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	11.2%	8.0%	16.4%	Гадаад актив, пассивын зөрүү, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	- 39.5%	- 38.2%	-31.8%	Итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	79.7%	78.7%	57.3%	Өрийн бичгийн өглөг, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	26.5%	37.0%	18.1%
Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2023	2024	2025																																	
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	27.7%	25.7%	27.0%																																	
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	29.6%	26.7%	30.6%																																	
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	11.2%	8.0%	16.4%																																	
Гадаад актив, пассивын зөрүү, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	- 39.5%	- 38.2%	-31.8%																																	
Итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	79.7%	78.7%	57.3%																																	
Өрийн бичгийн өглөг, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	26.5%	37.0%	18.1%																																	
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй	2025 онд ЛэндМН нь LendMN аппликейшнаар дамжуулан 133 мянган удаагийн олголтоор нийт 439 тэрбум төгрөгийн Flexi Business бизнесийн зээлийн санхүүжилтыг олгосон байна. Flexi Business зээлийн бүтээгдэхүүн нь 2024 оны IV улиралд нийт зээлийн багцын 23%-ийг бүрдүүлж байсан бол																																			

	салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	2025 оны IV улиралд 38%-д хүрч өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: - 72%-ийг эмэгтэй бизнес эрхлэгчид; - 36%-ийг 35 хүртэлх насны залуу бизнес эрхлэгчид; - 29%-ийг хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бизнесүүд эзэлж байна. • 2025 онд LendDy нэртэйгээр “одоо аваад дараа төлөх” (BNPL) үйлчилгээг санал болгож, энэхүү шийдлээр дамжуулан бизнес эрхлэгчид борлуулалтын сувгаа тэлж, орлогын урсгалаа илүү тогтвортой болгох боломжийг нэмэгдүүлэхийг зорилоо. • 2025 онд цаасан гэрээг халж, гэрээ байгуулах бүх процессыг LendMN аппликейшнээр дамжуулан гүйцэтгэдэг боллоо. • Компанийн төлөөлөгчийн газрыг дахин тохижуулж, Харилцагчдад илүү тав тухтай, тохилог орчныг бий болгохыг зорьсон бөгөөд байршлыг Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, “Алтан жолоо тауэр” оффисын 1 давхарт нүүлгэж, үйлчилгээг ойртууллаа. • 2025 онд бид харилцагчаа хамгаалдаг, ил тод, хариуцлагатай санхүүгийн байгууллага гэдгээ баталж, Монголын төдийгүй дэлхийн финтекийн салбарт анх удаа ‘Харилцагчийг Хамгаалах Сертификат’-ын шаардлагыг хангалаа.
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй болно.
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Компани тайлант хугацаанд нийт 133.0 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж 69.4 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна. Бонд: Жилийн 12-18.5% хүүтэй, 12 сарын хугацаатай, зээлжих зэрэглэлийн үнэлгээгээр баталгаажсан нийт 6 тэрбум төгрөгийн хаалттай бонд гарган эх үүсвэр татан төвлөрүүлсэн бол олон нийтэд нээлттэй болон хаалттай бондын нийт 14.0 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийг амжилттай гүйцэтгэсэн болно. Итгэлцэл: Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн нийт эх үүсвэрийн дүн өмнөх онтой харьцуулахад 4.5 тэрбумаар өссөн үзүүлэлттэй байна. Дотоодын санхүүгийн байгууллага: Компани 2025 онд дотоодын санхүүгийн байгууллагаас нийт 23.6 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж 55.34 тэрбумын эргэн төлөлтийг амжилттай гүйцэтгэсэн ба тус оны жилийн эцсийн байдлаар дотоодын санхүүгийн байгууллагаас авсан зээлийн үлдэгдэл 8.2 тэрбум төгрөг, 23.3 тэрбум төгрөгтэй тэнцэх зээлийн багцын барьцаатай байна.

		Олон улсын санхүүгийн байгууллага: Компани 2025 онд нийт 24.8 сая ам.долларын санхүүжилтийг гадны санхүүгийн байгууллагаас амжилттай татан төвлөрүүлсэн байна. Энэхүү санхүүжилт нь 35.8 сая ам.доллартай тэнцэхүйц харилцагчид олгосон зээлийн багцын барьцаатай болно. Хоёрдогч өглөг: Компани тайлант хугацаанд 10 тэрбум 780 сая төгрөгийн хоёрдогч өглөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн болно.												
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/													
	3.1 Их хэмжээний хэлцэл Тайлант хугацааны турш их хэмжээний хэлцэл хийгээгүй. 3.2 Сонирхлын зөрчилтэй хэлцэл 2025 онд Компанийн зээлийн үйл ажиллагааны өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх үүднээс холбоотой талаас санхүүжилт хүлээн авах, хувьцаа худалдан авах болон үйлчилгээ авахтай холбоотой нийт 8 сонирхлын зөрчилтэй хэлцэлд ЛэндМН-ийн ТУЗ-өөс Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрөл олгосон байна. <table><tr><th>№</th><th>Хэлцлийн нөгөө тал</th><th>Зөвшөөрөл олгосон огноо</th><th>Хэлцэл хийсэн зорилго</th></tr><tr><td>1</td><td>“Lendable Asset Management” LLC&AND FSG Pte.Ltd</td><td>2025.03.25</td><td>Компанийн нийт зарласан болон гаргасан хувьцааны 75 (далан тав) хувийг эзэмшдэг “АНД Системс” ХХК-ийн толгой компани болох “АНД ФСЖ Пти. Лтд” (“Толгой компани”) нь “Lendable Asset Management LLC”-ийн төлөөлөлтэй олон улсын хөрөнгө оруулагчдаас зээлийн санхүүжилт авч, олон талт, урт хугацаат зээлийн гэрээг байгуулан Компани руу дамжуулан зээлдүүлэх зорилгоор Компанитай 1) Хувьцаа эзэмшигчийн зээлийн гэрээ байгуулсан бөгөөд ийнхүү Компани нь санхүүжилтийг хүлээн авч буйн хувьд 2) Толгой компани болон Санхүүжүүлэгч талтай Олон талт зээлийн гэрээг байгуулж, Толгой компанийн Санхүүжүүлэгч талын өмнө хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хариуцахаар батлан даагчийн үүрэг хүлээсэн.</td></tr><tr><td>2</td><td>“ОНДО” ХХК</td><td>2025.05.09</td><td>Компани нь өөрийн оршин байгаа хаягаа өөрчилж, шинэ оффист нүүж ирсэнтэй холбогдуулан цаашид ашиглах боломжгүй тавилга, эд хогшлыг ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 24/41 тоот тогтоолын дагуу акталж, тус актлагдсан</td></tr></table>		№	Хэлцлийн нөгөө тал	Зөвшөөрөл олгосон огноо	Хэлцэл хийсэн зорилго	1	“Lendable Asset Management” LLC&AND FSG Pte.Ltd	2025.03.25	Компанийн нийт зарласан болон гаргасан хувьцааны 75 (далан тав) хувийг эзэмшдэг “АНД Системс” ХХК-ийн толгой компани болох “АНД ФСЖ Пти. Лтд” (“ Толгой компани ”) нь “Lendable Asset Management LLC”-ийн төлөөлөлтэй олон улсын хөрөнгө оруулагчдаас зээлийн санхүүжилт авч, олон талт, урт хугацаат зээлийн гэрээг байгуулан Компани руу дамжуулан зээлдүүлэх зорилгоор Компанитай 1) Хувьцаа эзэмшигчийн зээлийн гэрээ байгуулсан бөгөөд ийнхүү Компани нь санхүүжилтийг хүлээн авч буйн хувьд 2) Толгой компани болон Санхүүжүүлэгч талтай Олон талт зээлийн гэрээг байгуулж, Толгой компанийн Санхүүжүүлэгч талын өмнө хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хариуцахаар батлан даагчийн үүрэг хүлээсэн.	2	“ОНДО” ХХК	2025.05.09	Компани нь өөрийн оршин байгаа хаягаа өөрчилж, шинэ оффист нүүж ирсэнтэй холбогдуулан цаашид ашиглах боломжгүй тавилга, эд хогшлыг ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 24/41 тоот тогтоолын дагуу акталж, тус актлагдсан
№	Хэлцлийн нөгөө тал	Зөвшөөрөл олгосон огноо	Хэлцэл хийсэн зорилго											
1	“Lendable Asset Management” LLC&AND FSG Pte.Ltd	2025.03.25	Компанийн нийт зарласан болон гаргасан хувьцааны 75 (далан тав) хувийг эзэмшдэг “АНД Системс” ХХК-ийн толгой компани болох “АНД ФСЖ Пти. Лтд” (“ Толгой компани ”) нь “Lendable Asset Management LLC”-ийн төлөөлөлтэй олон улсын хөрөнгө оруулагчдаас зээлийн санхүүжилт авч, олон талт, урт хугацаат зээлийн гэрээг байгуулан Компани руу дамжуулан зээлдүүлэх зорилгоор Компанитай 1) Хувьцаа эзэмшигчийн зээлийн гэрээ байгуулсан бөгөөд ийнхүү Компани нь санхүүжилтийг хүлээн авч буйн хувьд 2) Толгой компани болон Санхүүжүүлэгч талтай Олон талт зээлийн гэрээг байгуулж, Толгой компанийн Санхүүжүүлэгч талын өмнө хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хариуцахаар батлан даагчийн үүрэг хүлээсэн.											
2	“ОНДО” ХХК	2025.05.09	Компани нь өөрийн оршин байгаа хаягаа өөрчилж, шинэ оффист нүүж ирсэнтэй холбогдуулан цаашид ашиглах боломжгүй тавилга, эд хогшлыг ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 24/41 тоот тогтоолын дагуу акталж, тус актлагдсан											

				тавилгуудаас 3,100,000 төгрөгийн үнэ бүхий оффисын зориулалттай 5 ширхэг тавилгыг “ОНДО” ХХК-д худалдсан.
	3	“ОНДО” ХХК	2025.07.09	“ОНДО” ХХК-тай 2022 онд байгуулсан “Интернетийн үйлчилгээний гэрээ”-ний хугацаа дууссантай холбогдуулан талууд харилцан тохиролцож тус хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тул гэрээнд хугацаа сунгах нэмэлт, өөрчлөлтийг оруулсан.
	4	“Lendable Asset Management” LLC&AND FSG Pte.Ltd	2025.10.14	Компанийн нийт зарласан болон гаргасан хувьцааны 75 (далан тав) хувийг эзэмшдэг “АНД Системс” ХХК-ийн толгой компани болох “АНД ФСЖ Пти. Лтд” (“Толгой компани”) нь “Lendable Asset Management LLC”-ийн төлөөлөлтэй олон улсын хөрөнгө оруулагчдаас зээлийн санхүүжилт авч буйг дээр дурдсаны дагуу тус олон талт “Санхүүжилтийн гэрээ”-ний хоёр дахь санхүүжилтийг олгохоор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан.
	5	“АНД Системс” ХХК (Толгой компани)	2025.10.20	Компанийн зээлийн шугамын хугацааг үргэлжлүүлэх зорилгоор “АНД Системс” ХХК-тай байгуулсан “Санхүүжилтийн гэрээ”-г шинэчлэн байгуулсан.
	6	“АНД Системс” ХХК (Толгой компани)	2025.12.01	Компанийн нийт зарласан болон гаргасан хувьцааны 75 (далан тав) хувийг эзэмшдэг “АНД Системс” ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай "Супер Ап Хэтэвч" ХХК-ийг групп компанийн зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан Компани өөрийн үйл ажиллагааг өргөжүүлэхээр худалдан авахаар шийдвэрлэсэн тул тус компанийн нийт энгийн хувьцааг худалдан авсан.
	7	“АНД Системс” ХХК (Толгой компани)	2025.12.01	Дээрх хувьцаа худалдан авахтай холбогдуулан тус хувьцаагаар гэрчлэгдэх эрхийг шилжүүлэх авах зорилгоор мөн өдөр “Хувьцааны эрх шилжүүлэх гэрээ”-г байгуулсан.
	8	“АНД Системс” ХХК (Толгой компани)	2025.12.15	Компанийн хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг хоёрдогч өглөг татах замаар нэмэгдүүлэхээр Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас шийдвэрлэсний дагуу Компанийн нийт зарласан болон гаргасан хувьцааны 75 (далан тав) хувийг эзэмшдэг “АНД Системс” ХХК-тай “Хоёрдогч өглөг байршуулах гэрээ”-г байгуулан 3 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн хоёрдогч өглөг татан төвлөрүүлсэн.
4.	Цалин урамшууллын мэдээлэл			

ТУЗ-ийн цалин урамшууллын мэдээлэл:

Компанийн ТУЗ-ийн 2025 оны цалингийн хэмжээ, зарцуулах төсвийг 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “ХЭЭХ”)-аас баталсан билээ. ТУЗ нь батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа ба нэмэлтээр шагнал, нөхөн олговор, бусад урамшуулал олгоогүй болно.

д/д	Зардлын зүйл	Гишүүдийн тоо	Сарын цалин (төгрөг)	Сар	Нийт төсөв (төгрөг)
1	Цалин урамшууллын төсөв	10	13,780,000	12	186,030,000
1.1	Дарга	1	1,950,000	12	23,400,000
1.2	Хорооны дарга	3	1,560,000	12	56,160,000
1.3	Гишүүн	5	1,300,000	12	78,000,000
1.4	Нарийн бичгийн дарга	1	650,000	12	7,800,000
1.5	НДШ-ийн зардал				20,670,000
2	Хурал болон бусад зардал				10,000,000
	НИЙТ ТӨСӨВ				196,030,000

Гүйцэтгэх захирлын цалин, шагнал урамшууллын мэдээлэл:

Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Гүйцэтгэх захирлын цалин, шагнал урамшууллын хэмжээг холбогдох хууль тогтоомж, Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны хурлаар хэлэлцэн тодорхойлдог бөгөөд шагнал урамшууллын хэмжээг санхүүгийн болон санхүүгийн бус үзүүлэлттэй уялдуулан жил бүр гаргасан гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн Гүйцэтгэх захирлын гэрээнд тусган баталгаажуулдаг.

2025 оны хувьд Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллыг олгохдоо дараах гүйцэтгэлийн шалгууруудыг тавьсан болно. Үүнд:

- Санхүүгийн үзүүлэлт
 - Зээлийн багц, орлого, ашиг
 - Чанаргүй зээлийн багц
- Санхүүгийн бус үзүүлэлт
 - Компанийн нэр хүндийг олон нийтийн болон салбарын дунд өсгөх

ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны зүгээс санхүүгийн жил дуусгавар болсны дараа Гүйцэтгэх захирлын тухайн хугацааны үйл ажиллагаа нь Гүйцэтгэх захирлын гэрээнд туссан санхүүгийн болон санхүүгийн бус үзүүлэлтүүдэд хүрч буй эсэх буюу Компанийн жилийн үйл ажиллагааны нөхцөл байдалтай нэг бүрчлэн харьцуулан тодорхойлж, шагнал урамшуулал олгох эсэхийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэх бодлогыг баримталж байна.

Компанийн ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 26/04 тоот тогтоолоор Гүйцэтгэх захиралд 202 оны үр дүнгийн урамшуулал олгохоор шийдвэрлээд байна.

5.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i> “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “ЛэндМН”) нь Монгол Улсын хууль тогтоомж болон Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компани болохынхоо хувьд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, түүнчлэн Монголбанкны холбогдох журам, засаглалын дүрэм, кодексыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. ЛэндМН нь зохистой засаглал, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангахад онцгойлон анхаарч, улмаар удирдлагын баг, төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцааг төгөлдөржүүлэх, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн урт хугацаанд тогтвортой үнэ цэнийг бий болгохыг үргэлж зорьсоор ирсэн юм. Компани нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, оролцогч талуудтай үр дүнтэй холбоо үүсгэх, санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөв, цаг алдалгүй хүргэх зорилгоор үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн талаар улирал бүрийг болон хагас жилийн хугацааг хамруулан мэдээлэх стратегийг баримталж, нийт 3 удаагийн тайлан гарган олон нийтэд хүргээд байна. Ийнхүү 2025 онд 2024 оны БОНЗ-ын тайланг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр, 2025 оны I улирлын тайланг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр, 2025 оны хагас жилийн тайланг 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдөр, 2025 оны III улирлын тайланг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр тус тус гарган олон нийтэд мэдээлснээр Компанийн бизнес, засаглал, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх мэдээллийг тухай бүр авах боломжийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, харилцагчид болон оролцогч талуудад олгож, харилцан итгэлцэл, эргэх холбоо бүхий хамтын ажиллагааг бий болгосон юм. Мөн 2025 оны эхний хагаст багтаан 2024 оны БОНЗ-ын тайланг анх удаа гарган МХБ болон олон нийтэд мэдээлсэн нь онцлох үйл явдал боллоо. Тус тайлангийн зорилго нь тогтвортой байдлын талаар компанийн баримталж буй бодлого, байгаль орчин, нийгэмд үзүүлж буй нөлөөллийг олон нийтэд ил тод хүргэх явдал бөгөөд компани нь цаашид жил бүр БОНЗ-ын тайланг гаргаж, олон нийтэд мэдээлэн ажиллахыг зорьж байна. Түүнчлэн, Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллалаа. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЛэндМН нь 2025 онд 8 дахь жилдээ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг тасалдуулахгүй амжилттай зохион байгуулан ажиллалаа. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол улсын Компанийн тухай хуульд заасны дагуу Компанийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр “Галлериа Улаанбаатар төв (Galleria Ulaanbaatar Center)”-ын 3 давхарт байрлах Juulchin Grand Ballroom танхимд зохион байгуулсан ба саналын эрх бүхий хувьцааны 81.64% буюу 603,574,846 ширхэг хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсоноор тус хурал хүчин төгөлдөр болсон ба дараах асуудлыг хэлэлцэн баталсан юм. Үүнд: - Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
----	--

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны төсвийг батлах;
- Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлуудыг шийдвэрлэн батлав.

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “ХЭЭБХ”)-ыг Монгол улсын Компанийн тухай хуульд заасны дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 25/42 дугаар тогтоолоор анх удаа зарлаж, улмаар 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хооронд эчнээ санал хураалтын хэлбэрээр амжилттай зохион байгууллаа. Тус ээлжит бус хуралд саналын эрх бүхий хувьцааны 81.16% буюу 600,014,913 ширхэг хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар саналаа ирүүлснээр тус хурал хүчин төгөлдөр болсон ба дараах асуудлыг хэлэлцэн баталсан юм. Үүнд:

- “АНД Системс” ХХК-иас хоёрдогч өглөг хэлбэрээр Компанийн хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх эсэх;
- Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлуудыг шийдвэрлэн батлав.

ЛэндМН-ийн Хувьцаа эзэмшигчид ээлжит болон ээлжит бус хуралдаа идэвхтэй оролцож, ЛэндМН-ийн цаашдын хөгжил, үйл ажиллагаа болоод хэлэлцэх асуудалтай холбоотойгоор Удирдлагын баг, хурал зохион байгуулах комиссоос мэдээлэл авч, мөн өөрийн санал, хүсэлтээ илэрхийлж байв. ЛэндМН-ийн зүгээс өмнөх жилүүдэд ашигласан цахим санал хураалтын системийг энэ удаагийн ХЭЭХ-д ашигласан нь санал хураалтын дүнг түргэн шуурхай гаргах боломжийг бүрдүүлж, хурлын үр дүнтэй Хувьцаа эзэмшигчид богино хугацаанд танилцах боломжийг олгосноороо онцлог байсан бол ХЭЭБХ-ын хувьд брокер, дилерийн компаниар дамжуулан эсхүл өөрийн “Харилцагчид үйлчлэх төв”-өөр дамжуулан эчнээ санал хураалтыг зохион байгуулав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (ЦААШИД “ТУЗ”)-ИЙН ХУРАЛ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТУЗ нь Компанийн үйл ажиллагааг бэхжүүлэх, зохистой түвшинд удирдах, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг хэрэгжүүлэх, стратегийн зорилтдоо хүрэхэд Компанийг ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ Гүйцэтгэх удирдлагад компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ЛэндМН-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн ердийн 6, хараат бус 3 гишүүнийг улируулан сонгосон. ТУЗ-ийн ердийн 6 гишүүнээр Монгол Улсын иргэн О.Болдбаатар, Ц.Ууганбаяр, Б.Хос-Эрдэнэ, Ц.Одмаа, С.Энх-Амгалан, Япон Улсын иргэн Кацухико Мадоно нар сонгогдсон бол ТУЗ-ийн Хараат бус 3 гишүүнээр Монгол Улсын иргэн Ж.Жаргалсүрэн, С.Боргил, С.Нэргүй нар тус тус улиран сонгогдсон болно. Ийнхүү ТУЗ-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлаар ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн даргыг сонгож, ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн болон ТУЗ-ийн 2025 оны ээлжит хурлын хуваарийг шинэчлэн баталлаа.

ТУЗ нь 2025 онд 5 удаа ээлжит хурал, 9 удаа эчнээ санал хураалт явуулан нийт 59 тогтоол гаргажээ. ТУЗ-ийн тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлээд байна.

ТУЗ-ийг эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг, байнгын ажиллагаа бүхий 1/ Эрсдэл ба БОНЗ-ын удирдлагын хороо, 2/ Аудитын хороо,

3/ Засаглал, нэр дэвшүүлэх хороо болон 4/ Цалин урамшууллын хороод үйл ажиллагаа явуулж байна.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эрсдэл ба БОНЗ-ын удирдлагын хороо (цаашид “ЭБОНЗУХ”)

ЭБОНЗУХ нь тайлант жилийн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, Компанийн бизнесийн хөгжил, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нөхцөл байдалтай тухай бүр танилцан хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

ЭБОНЗУХ-ны бүрэлдэхүүн: ЭБОНЗУХ -ны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн С.Нэргүй, гишүүдээр ТУЗ-ийн гишүүн С.Энх-Амгалан, Кацухико Мадоно, Ц.Ууганбаяр, Б.Хос-Эрдэнэ нар ажиллаж байна.

Аудитын хороо

Аудитын хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, 4 удаагийн эчнээ санал хураалтаар Компанийн дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудиторын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд болон нэгжид өгч ажиллалаа. Түүнчлэн, Компанийн зүгээс хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргах, Компанийн Дотоод аудиторыг томилох, Компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах хөндлөнгийн аудитын байгууллагыг томилох, Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байлгахад анхаарч мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэж буй эсэхэд хяналт тавьж ажилласан байна.

Аудитын хорооны бүрэлдэхүүн: Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Жаргалсүрэн, гишүүдээр ТУЗ-ийн гишүүн Ц.Одмаа, ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Боргил нар ажиллаж байна.

Засаглал, нэр дэвшүүлэх хороо (цаашид “ЗНДХ”)

ЗНДХ нь тайлант жилийн хугацаанд нийт 1 удаа хуралдаж, ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг шинээр сонгох асуудлыг хэлэлцэн Компанийн ХЭЭХ-д танилцуулан шийдвэрлүүлэх тухай шийдвэрлэж, мөн Компанийн мөрдөж буй ажлын үр дүнтэй холбоотой урамшууллын системийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгч, гүйцэтгэх захирлын томилгоо, гүйцэтгэх захирлын урамшуулалтай холбоотой дүгнэлт гарган ажилласан байна.

ЗНДХ-ны бүрэлдэхүүн: ЗНДХ-ны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн С.Боргил, гишүүдээр ТУЗ-ийн дарга О.Болдбаатар, ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Жаргалсүрэн нар ажиллаж байна.

Цалин, урамшууллын хороо (цаашид “ЦУХ”)

ЦУХ нь тайлант жилийн хугацаанд 1 удаа хуралдаж, Компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, ажиллагсдын тэтгэврийн даатгалын болон хувьцаа эзэмшүүлэх аливаа хөтөлбөрийг судалж, сонголт хийх гэх мэт чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.

ЦУХ-ны бүрэлдэхүүн: ЦУХ-ны даргаар С.Нэргүй, гишүүдээр ТУЗ-ийн гишүүн Ц.Одмаа, ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Боргил нар ажиллаж байна.

ТУЗ-ийн гишүүдийн ирц, ажилласан хугацааны мэдээлэл:

д/д	ТУЗ-ийн гишүүдийн нэрс	2025 оны ТУЗ-ийн хурлын ирц	ТУЗ-д ажилласан хугацаа, туршлага	Компанид хувьцаа эзэмшдэг эсэх
1	О.Болдбаатар	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 8 дахь жилдээ ажиллаж байна	Нийт хувьцааны 0.0073%
2	С.Энх-Амгалан	92.9%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 8 дахь жилдээ ажиллаж байна	Нийт хувьцааны 0.085%
3	Кацухико Мадоно	85.7%	ХЭЭХ-аас сонгогдож, 2 дахь жилдээ ажиллаж байна	Нийт хувьцааны 0.0028%
4	С.Нэргүй	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 2 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	Үгүй
5	Б.Хос-Эрдэнэ	92.9%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 4 дэх жилдээ ажиллаж байна	Үгүй
6	Ц.Ууганбаяр	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 4 дэх жилдээ ажиллаж байна	Нийт хувьцааны 0.0026%
7	Ж.Жаргалсүрэн	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 8 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	Үгүй
8	С.Боргил	92.9%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 8 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	Нийт хувьцааны 0.0009%
9	Ц.Одмаа	71.4%	ХЭЭХ-аас сонгогдож, 3 дахь жилдээ ажиллаж байна	Үгүй

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн холбогдох журам, кодекс, түүнчлэн Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бие даан гаргадаг. ТУЗ-ийн аливаа шийдвэр нь олонхын саналаар хүчин төгөлдөр болдог ба ТУЗ-ийн гишүүн нь хэлэлцэж буй асуудлаар “дэмжсэн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” санал гаргах боломжтой. ТУЗ-ийн гишүүд нь тайлант хугацаанд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, хичээл зүтгэл гарган ажилласан гэдгийг ТУЗ-ийн хурлын ирцээс харж болох бөгөөд Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай, ач холбогдолтой шийдвэрүүдийг холбогдох баримт бичиг, судалгаа, тайлбар дүгнэлттэй нэг бүрчлэн танилцсаны үндсэн дээр цаг алдалгүй гаргаж, Компанийн 202 оны амжилтын голлох хүчин зүйлсийн нэг болсон юм.

ТУЗ-ийн хурлын тогтоол, төрөл болон бусад мэдээлэл

д/д	Шийдвэр гаргасан огноо	Ирц	Шийдвэр гаргасан хэлбэр	Баталсан тогтоолын тоо
1	2025 оны 02 дугаар сарын 06	88.89%	Ээлжит хурал	11
2	2025 оны 03 дугаар сарын 06	77.78%	Эчнээ санал хураалт	1
3	2025 оны 03 дугаар сарын 25	100%	Эчнээ санал хураалт	3
4	2025 оны 05 дугаар сарын 09	100%	Ээлжит хурал	17
5	2025 оны 06 дугаар сарын 18	100%	Эчнээ санал хураалт	3
6	2025 оны 07 дугаар сарын 07	77.78%	Эчнээ санал хураалт	1
7	2025 оны 08 дугаар сарын 06	77.78%	Ээлжит хурал	5
8	2025 оны 09 дүгээр сарын 03	88.89%	Эчнээ санал хураалт	1
9	2025 оны 10 дугаар сарын 13	100%	Эчнээ санал хураалт	2
10	2025 оны 10 дүгээр сарын 17	100%	Эчнээ санал хураалт	2
11	2025 оны 10 дугаар сарын 27	100%	Ээлжит хурал	14
12	2025 оны 11 дүгээр сарын 13	100%	Эчнээ санал хураалт	1
13	2025 оны 11 дүгээр сарын 28	100%	Эчнээ санал хураалт	2
14	2025 оны 12 дугаар сарын 18	100%	Ээлжит хурал	6

Удирдлага зохион байгуулалт	Санхүү	Эрх олгох	Үйл ажиллагаа	Бизнес стратеги
9	10	18	14	8

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ЫН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа даган мөрдөж, 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 93%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. Түүнчлэн, “Компанийн засаглалын кодекс” нь тасралтгүй хэрэгжиж, үйл ажиллагааны онцлогоос хамаарч үнэлгээ нь тухай бүр шинэчлэгддэг онцлогтой тул Компанийн зүгээс 100%-ийн гүйцэтгэлд хүрэхийн тулд хүчин зүтгэл гарган ажиллах болно.

№	Үндсэн зарчим	Авбал зохих нийт оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10	83.3%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	5	83.3%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4	66.6%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
8	Компанийн соёл	6	6	100%

	9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%						
		Нэгдсэн дүн	72	67	93%						
БУСАД ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ											
2025 оны байдлаар дараах тайлан, мэдээллүүдийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хугацаанд илгээж, олон нийтэд мэдээлсэн байна. Үүнд: • 2024 оны жилийн санхүү болон үйл ажиллагааны тайлан; • 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт; • 2024 оны БОНЗ-ын тайлан; • 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлын шийдвэр, тэмдэглэл холбогдох баримт бичгүүд; • 2025 оны I улирлын үйл ажиллагааны тайлан; • 2025 оны эхний хагас жилийн тайлан; • 2025 оны III улирлын үйл ажиллагааны тайлан; • 2025 онд ТУЗ-өөс гарсан тогтоолууд; • Компанийн бүтээгдэхүүн, үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээллүүд. Түүнчлэн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Компанийн сошиал сувгууд болон харилцагчийн үйлчилгээний төвийн 77070101 тоот утсаар харилцагч, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын санал, хүсэлт, асуултад тухай бүр хариу өгч, мэдээлэл солилцон ажилласан байна.											
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл										
	ЛэндМН нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагчид болон хамтран ажиллагч нарынхаа итгэлийг хүлээж бизнесийн ёс зүйг эрхэмлэн ажиллаж, сайн засаглалын хүрээнд Эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж ажилласаар ирлээ. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан Эрсдэлийн удирдлагын бодлогоор “Гурван шугамын загвар”-ыг дараах байдлаар тодорхойлон компанийн бүх нэгжүүдийн чиг үүрэг, төлөвлөгөө, гүйцэтгэлийн үнэлгээг уялдуулан ажиллаж байна.										
	<table><tr><th>I шугам</th><th>II шугам</th><th>III шугам</th></tr><tr><td>Эрсдэлийг хариуцаж, удирдах эзэн буюу нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой гарах эрсдэлийг тодорхойлох, илрүүлэх, хариу арга хэмжээ авах, хяналтад байлгах, удирдах</td><td>Хамгаалалтын I бүсийн эрсдэлийн удирдлага, хяналтын зохион байгуулалт, үйл ажиллагаанд мониторинг хийх, заавар, зөвлөмжөөр хангах, дэмжлэг үзүүлэх</td><td>Хамгаалалтын I бүсийн хэрэгжүүлж буй хяналтын тогтолцоо, II бүсийн хэрэгжүүлж буй хянан нийцүүлэлт, үнэлгээ, тайлагналын үр дүнтэй байдалд хараат бус үнэлэлт, дүгнэлт өгөх</td></tr></table>					I шугам	II шугам	III шугам	Эрсдэлийг хариуцаж, удирдах эзэн буюу нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой гарах эрсдэлийг тодорхойлох, илрүүлэх, хариу арга хэмжээ авах, хяналтад байлгах, удирдах	Хамгаалалтын I бүсийн эрсдэлийн удирдлага, хяналтын зохион байгуулалт, үйл ажиллагаанд мониторинг хийх, заавар, зөвлөмжөөр хангах, дэмжлэг үзүүлэх	Хамгаалалтын I бүсийн хэрэгжүүлж буй хяналтын тогтолцоо, II бүсийн хэрэгжүүлж буй хянан нийцүүлэлт, үнэлгээ, тайлагналын үр дүнтэй байдалд хараат бус үнэлэлт, дүгнэлт өгөх
	I шугам	II шугам	III шугам								
Эрсдэлийг хариуцаж, удирдах эзэн буюу нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой гарах эрсдэлийг тодорхойлох, илрүүлэх, хариу арга хэмжээ авах, хяналтад байлгах, удирдах	Хамгаалалтын I бүсийн эрсдэлийн удирдлага, хяналтын зохион байгуулалт, үйл ажиллагаанд мониторинг хийх, заавар, зөвлөмжөөр хангах, дэмжлэг үзүүлэх	Хамгаалалтын I бүсийн хэрэгжүүлж буй хяналтын тогтолцоо, II бүсийн хэрэгжүүлж буй хянан нийцүүлэлт, үнэлгээ, тайлагналын үр дүнтэй байдалд хараат бус үнэлэлт, дүгнэлт өгөх									
Эрсдэл хариуцсан нэгж нь Финтек зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл болон харилцагчаас хамаарч үүсэх эрсдэлийг тус тус үнэлж холбоотой эрсдэлийг бууруулах зөвлөмж хүргүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан үе шаттайгаар тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна.											

"Зээлийн эрсдэлийн удирдлага"

Зээлийн эрсдэл гэдэг нь зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас ББСБ алдагдал хүлээх магадлалыг хэлнэ. ЛэндМН нь зээлийн эрсдэлийн удирдлага нь эрсдэлийн тодорхой орчин нөхцөлд тохируулан эрсдэлийн нөлөөллийг удирдах замаар компанийн ашигт ажиллагаа, өгөөжийг хамгийн өндөр түвшинд байлгахад чиглэдэг.

"Комплаенсын эрсдэлийн удирдлага"

Компани нь бизнесийн үйл ажиллагаандаа Монгол улсын хэмжээнд хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагын дүрэм журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг авч ажиллаа. Үүнд:

- Компанийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтын хөтөлбөр болон журмыг шинэчлэн батлав.
- ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны төлөөллийг чадавхжуулах, комплаенсын мэдлэг, манлайллын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалтад хамруулав.
- Компанийн үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын дүрэм журамд нийцэж буй эсэх болон компанийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлгээг ТУЗ-д танилцуулав.
- Эрх бүхий албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор "Ашиг сонирхлын зөрчлийг мэдүүлэх" зохицуулалтын баримт бичгийн шинэчлэлийн ажлыг эхлүүлэв.

ЛэндМН-ийн голлох эрсдэлүүд:

Гол эрсдэлүүд	Эрсдэл, үр дагавар, нөлөөлөл	Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт
Зах зээлийн эрсдэл	- Эх үүсвэр болон активын хүүгийн зөрүүгээс санхүүгийн алдагдал хүлээх. - Эдийн засгийн нөхцөл байдал болон бодлогын аливаа өөрчлөлтөөс болж санхүүгийн алдагдалд хүрэх	- Гадаад валютын нээлттэй позицийг зохистой түвшинд барин ажиллав. - Эх үүсвэр, активын удирдлагыг оновчтой хэрэгжүүлсэн. - Гадаад валют, үнэт цаасны ханшийн хэлбэлзлийг тооцон ажиллав. - Аливаа өөрчлөлтүүдийн талаар цаг тухайд нь мэдээлэлтэй байж, арга хэмжээг авч ажиллав.
Санхүүгийн эрсдэл	- Зохистой харьцааны үзүүлэлт алдагдах. - Төлбөрийн чадвар алдагдах буюу хөрөнгө оруулагчийн мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар буцаан төлөх боломжгүй болох.	- Төлөвлөлт хангалттай хэрэгжүүлсэн. - Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн. - Эх үүсвэрийн төвлөрлийг удирдсан.

		- Зээлийн эрэлт, өсөлтийг хангахгүй болох.	- Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулсан бодлого чиглэл баримталж ажиллалаа.
	Зээлийн эрсдэл	- Зээлийн багцын чанар буурах - Зээл төлөгдөхгүй байх магадлал (PD) болон зээлийн алдагдал үүсэх (LGD) магадлал нэмэгдэх - Зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн хэмжээ өсөх	- Багцын чанарын мониторингийг хэрэгжүүлж Удирдлагын баг болон Эрсдэлийн Хороонд тогтмол тайлагнаж, уялдаа холбоотой ажилладаг. - Зээлийн багц, эргэн төлөлттэй холбоотой тайлан мэдээний загварчлалыг тогтмол сайжруулж Удирдлагын багийг хэрэгцээт мэдээ мэдээллээр тогтмол хангаж ажиллаж байна. - Зээлийн скорингийн сайжруулалтыг хийж ажилласан.
	Үйл ажиллагааны эрсдэл	- Биет эд хөрөнгийн зардал - Бизнесийн үйл ажиллагааны тасалдал үүсэх - Санхүүгийн хохирол гарах - Санхүүгийн бус хохирол гарах	- Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц гадаад, дотоод эрсдэлийг үнэлж, эрсдэлийн магадлалыг бууруулах төлөвлөгөөг гарган, хэрэгжүүлж, тайлагнаж ажиллалаа. - Эрсдэлийн үнэлгээнд суурилсан дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллав.
	Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл	- Мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдал алдагдах - Мэдээллийн бааз гэмтэх, усах. - Системийн эмзэг байдлыг ашиглах	- Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 27001:2013 стандартаас ISO 27001:2022 стандартад шилжиж олон улсын байгууллагаар сертификатаа баталгаажуулав. - Системийн эмзэг байдлыг бууруулах, цахим халдлагаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд тогтмол аюулгүй байдлын тест хийх, шинэ технологи нэвтрүүлэх зэргээр тасралтгүй сайжруулалтыг хийж ажиллаж байна.
	Байгаль орчин,	- Байгаль орчинд хохиролтой үйл ажиллагааг санхүүжүүлэх	- Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргахдаа хуулийн нийцэл

	нийгмийн хариуцлага	- Нийгмийн хариуцлагын үйл ажиллагааг шийдвэр гаргалтад чухалчилж үзэхгүй байх	болон байгаль орчин нийгэмд ээлтэй байдлыг харгалзан үзэж холбогдох эрсдэлийн үнэлгээг хийж, шийдвэр гарган ажиллаж байна. - Нийгмийн хариуцлагын хүрээнд компанит ажлуудыг хэрэгжүүлэхээс гадна санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд ажиллаж байна.																				
7.	<i>Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/</i>																						
	<table border="1"> <thead> <tr> <th>№</th><th>Хувьцаа эзэмшигч</th><th>Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг)</th><th>Эзэмшлийн хувь</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td>“АНД Системс” ХХК</td><td>600,000,000</td><td>75%</td></tr> <tr> <td>2</td><td>Олон нийт</td><td>139,301,683</td><td>17.41%</td></tr> <tr> <td></td><td>Халаасны хувьцаа</td><td>60,698,317</td><td>7.58%</td></tr> <tr> <td></td><td>Нийт</td><td>800,000,000</td><td>100%</td></tr> </tbody> </table> Хувьцаа эзэмшигчдийн тоо: 11,705 (2026.01.07-ны өдрийн тархалтын судалгаагаар, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид давхардаагүй тоогоор). Тайлант хугацаанд компани эргүүлэн худалдан авсан халаасны хувьцаа байхгүй ба ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх, урамшуулах хөтөлбөр хэрэгжүүлээгүй болно. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн халаасны хувьцаа 60,698,317 ширхэг байна.			№	Хувьцаа эзэмшигч	Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг)	Эзэмшлийн хувь	1	“АНД Системс” ХХК	600,000,000	75%	2	Олон нийт	139,301,683	17.41%		Халаасны хувьцаа	60,698,317	7.58%		Нийт	800,000,000	100%
№	Хувьцаа эзэмшигч	Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг)	Эзэмшлийн хувь																				
1	“АНД Системс” ХХК	600,000,000	75%																				
2	Олон нийт	139,301,683	17.41%																				
	Халаасны хувьцаа	60,698,317	7.58%																				
	Нийт	800,000,000	100%																				
8.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</i>																						
	“ЛэндМН ББСБ” ХК нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.																						
9.	<i>Ногдол ашгийн мэдээлэл</i>																						
	“ЛэндМН ББСБ” ХК-ийн Ногдол ашгийн бодлогын дагуу 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 25/03 тоот тогтоолоор “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 15.0 төгрөг буюу нийт 11,089,525,245 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсний дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг шилжүүлсэн болно.																						

	2025 оны ногдол ашгийн хувьд ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын 26/03 тоот тогтоолоор “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2025 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 16.5 төгрөг буюу нийт 12,198,477,769.5 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ. Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (tengger) Цэвэр ашиг <table><thead><tr><th>Year</th><th>Net Profit per Share (Tengger)</th><th>Total Net Profit (Tengger)</th></tr></thead><tbody><tr><td>2020</td><td>0.58</td><td>224 тэрбум</td></tr><tr><td>2021</td><td>1.50</td><td>389 тэрбум</td></tr><tr><td>2022</td><td>1.75</td><td>552 тэрбум</td></tr><tr><td>2023</td><td>8.0</td><td>1979 тэрбум</td></tr><tr><td>2024</td><td>15.0</td><td>3621 тэрбум</td></tr><tr><td>2025</td><td>16.5</td><td>4015 тэрбум</td></tr></tbody></table> 2025 оны ногдол ашгийг 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн дансанд байршуулж, Хувьцаа эзэмшигчдийн дансанд дамжуулан олгохоор шийдвэрлэв.	Year	Net Profit per Share (Tengger)	Total Net Profit (Tengger)	2020	0.58	224 тэрбум	2021	1.50	389 тэрбум	2022	1.75	552 тэрбум	2023	8.0	1979 тэрбум	2024	15.0	3621 тэрбум	2025	16.5	4015 тэрбум
Year	Net Profit per Share (Tengger)	Total Net Profit (Tengger)																				
2020	0.58	224 тэрбум																				
2021	1.50	389 тэрбум																				
2022	1.75	552 тэрбум																				
2023	8.0	1979 тэрбум																				
2024	15.0	3621 тэрбум																				
2025	16.5	4015 тэрбум																				
10	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл																					
	ЛэндМН нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд дараах ажлуудыг 2025 онд хийж гүйцэтгэлээ. Үүнд: - "Алтан Од" багийг ивээн тэтгэв. Бид бизнес эрхлэгчдээс гадна эмэгтэйчүүдийн манлайлал, хүний хөгжил, нийгмийн эерэг өөрчлөлтийг дэмжин Монголын Сагсан бөмбөгийн эмэгтэй дээд лигийн баг болох "Алтан Од" багийг ивээн тэтгэж, хамтран ажиллаж эхэллээ. - Боловсролд хөрөнгө оруулав. Монгол Улсын Засгийн газраас зарласан тэргүүлэх чиглэлээр Шанхай хот дахь New York University-д суралцаж буй оюутан Г.Мишээлд сургалтын төлбөрт нь хариу төлбөргүйгээр санхүүгийн дэмжлэг үзүүлэв. - Бизнес эрхлэгчдийг чадавхжуулах нь арга хэмжээг хамтран зохион байгуулав. Компани нь Монголын Бизнесийн Зөвлөлтэй хамтран “Бичил, Жижиг, Дунд Бизнесийг чадавхжуулах нь” сэдэвт арга хэмжээг амжилттай зохион байгуулж, салбарын нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх боломж болон технологийн шийдлүүдийн талаар өргөн хүрээний хэлэлцүүлгийг өрнүүллээ. - Үйл ажиллагаагаа санхүүгийн хүртээмж рүү чиглүүлж байна. Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээр Монгол Улсад 2025 оны байдлаар 233 мянга гаруй хувиараа бизнес эрхлэгч үйл ажиллагаа явуулж байгаагийн ердөө 90 мянга гаруй бизнес эрхлэгч л санхүүгийн байгууллагаас бизнесийн зээл авч,																					

	үйл ажиллагаандаа хөрөнгө оруулж байгаа бол үлдсэн 133 мянга гаруй бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч нар санхүүжилтийн хүртээмжгүй байдлаас шалтгаалан бизнесээ тогтвортой үргэлжлүүлэх, цаашлаад тэлэх бодит боломж нь хязгаарлагдмал хэвээр байна. ЛэндМН энэхүү орон зайг нөхөх зорилгоор өнгөрсөн 8 жилийн хугацаанд тасралтгүй сайжруулсан скорингийн аргачлал, өгөгдөлд суурилсан үнэлгээг ашиглан барьцаагүй, бүрэн дижитал, 5 минутын дотор шийдвэрлэдэг Flexi Business зээлийн бүтээгдэхүүнээр өнөөдрийн байдлаар 10 мянга гаруй бизнесүүдийг санхүүжүүлж, санхүүгийн хүртээмжийг бодитоор нэмэгдүүлэн ажиллаж байна. Ингэснээр зөвхөн тогтворжсон бизнесүүд төдийгүй тогтворжиж буй, өсөлтийн эхний шатандаа яваа бизнесүүд ч санхүүжилтэд хамрагдах боломж бүрдэж байгаа юм.
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Ц.Ууганбаяр Албан тушаал: “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Гарын үсэг: (Тамга/тэмдэг)	 /Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Х.Хулан Албан тушаал: “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Гарын үсэг: Огноо: 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр	



Shape the future
with confidence

Ernst & Young Mongolia Audit LLC
15/F, Altan Joloo Tower
Seoul Street 13/A
Ulaanbaatar 14252
Mongolia

Tel : +976 11 314032 / +976 11 312005
ey.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид ЛэндМН ББСБ ХК ("Компани") болон түүний охин компаниуд (хамтад нь "Групп" гэх) -ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр дурдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Группийн нэгтгэсэн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөл ("ОУНББСЗ")-өөс баталж гаргасан СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартуудын дагуу материаллаг алдаагүй, бодитойгоор илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт ("АОУС")-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"-ийн дагуу Группээс хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд гэдэг нь тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их ач холбогдолтой байсан гэж аудиторын мэргэжлийн үнэлэмжээр үзсэн асуудлууд юм. Эдгээр асуудлуудыг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь анхаарч, аудиторын дүгнэлт өгөхдөө авч үзсэн бөгөөд бид уг асуудлуудын талаар тусдаа дүгнэлт гаргадаггүй болно. Аудитын гол асуудлыг бид хэрхэн авч үзсэн талаарх тайлбарыг дор өгөв.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт дурдсан үүрэг хариуцлагууд болон эдгээр асуудлуудтай холбоотой үүрэг хариуцлагыг бид бүрэн биелүүлсэн. Үүний дагуу бид нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээнд тохирсон аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Дор дурдсан асуудлыг анхаарч үзэхдээ гүйцэтгэсэн горимуудыг багтаасан аудитын горимуудын үр дүн нь энд хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад өгсөн бидний аудитын дүгнэлтийн үндэслэл болно.



Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (Үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд (Үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд	Гүйцэтгэсэн аудитын горимууд
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралт Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлыг Группийн удирдлага нь тодорхой хэмжээний мэргэжлийн үнэлэмж ашиглан, өндөр түвшний төсөөлөлд үндэслэн тооцдог. Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Группийн нийт хөрөнгийн 90.5 хувиас дээш хувийг бүрдүүлдэг тул тэдгээртэй холбогдох тооцооллын тодорхойгүй байдал нь өндөр гэж бид үзсэн. Иймээс зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлын үнэлгээг бид аудитын гол асуудал гэж үзсэн. Үнэ цэнийн бууралтын аргачлал нь ирээдүйг таамагласан Хүлээгдэж буй зээлийн алдагдлын ("ХБЗА") загварт үндэслэдэг. ХБЗА загварын тодорхой элементүүдэд удирдлагаас мэдэгдэхүйц хэмжээний тооцоолол болон таамаглал гаргах шаардлага тулгардаг. Үүнд дараах зүйлс багтана: • Санхүүгийн хөрөнгийн шатлал; • ЗҮЦХА-ын загвар боловсруулах, загварын гол өгөгдлүүд болох Төлбөр төлөгдөхгүй байх магадлал ("ТТБМ") болон Алдагдал үүсэх магадлал ("АҮМ")-ийг сонгох; • Чанаргүйдэлд Өртөх Дүн ("ЧӨД") болон ашиглагдаагүй зээлийн үүргийн хөрвүүлэлтийн коэффициентийг тодорхойлох; • ЗҮЦХА-ын загварт оруулах эдийн засгийн өгөгдлүүдийг тодорхойлохын тулд ирээдүйн макро эдийн засгийн хувилбаруудыг сонгох, мөн тэдгээрийг магадлалаар нь жинлэх; болон • Ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалыг тооцоход хэрэглэсэн олон төрлийн төсөөлөл болон хүчин зүйлс дээр суурилан тусгайлан үнэлсэн зээлүүдийн үнэ цэнийн бууралтын санг тооцоолох. • Барьцааны зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох.	
	2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны хүлээгдэж буй зээлийн эрсдлийн санг үнэлэхтэй холбоотойгоор бидний аудитын ажиллагаа нь Группийн ХБЗА загварт ашигласан арга зүй, өгөгдөл, төсөөллүүдийг үнэлэх зэрэг аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Арга зүйг үнэлэхдээ бид группийн ХБЗА-ын загвар болон ашигласан арга зүй, таамаглалын удирдлагын үндэслэлийн талаарх ойлголтыг авч, загварын үндэслэлтэй байдлыг үнэлж, салбарын жишигтэй харьцуулсан. Түүнчлэн бид ашигласан таамаглалуудын үндэслэлтэй байдал, шатлалын ангиллын үндэслэл, ТТБМ, АҮМ болон ЧӨД-г тодорхойлох оновчтой байдал, загварт тусгагдсан макро эдийн засгийн хэтийн хувьсагчдыг авч үзсэн. Шатлалын ангилал зохистой эсэхийг шалгахдаа бид зээлийн хугацаа хэтрэлтийн мэдээлэл, харилцагчдад оноосон зээлжих зэрэглэлийг анхны хүлээн зөвшөөрсөн өдрөөр болон санхүүгийн тайлангийн өдрөөр тус тус шалгасан. Бид мөн насжилтын тайлангийн дүнг санхүүгийн бүртгэлд тусгасан дүнтэй тулгах замаар насжилтын тайлангийн иж бүрэн байдлыг шалгаж, санамсаргүй түүврийн аргаар насжилтын тайлангийн мэдээллүүдийг холбогдох баримтуудтай тулгах замаар насжилтын тайлангийн үнэн зөв байдлыг шалгасан. Бид ХБЗА-ын загварт ашигласан гол өгөгдлүүдийг Группийн боломжит дотоод эх үүсвэрээс олж авсан түүхэн мэдээлэл, гадаад эх үүсвэрээс олж авсан тухайн салбарын болон санхүү, эдийн засгийн мэдээллүүдтэй харьцуулсан. Бидний хяналтын горимд дараах ажлууд багтсан. Үүнд:



Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (Үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд (Үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд	Гүйцэтгэсэн аудитын горимууд
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралт	
Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлого болон нягтлан бодох бүртгэлийн гол тооцооллууд болон үнэлэмжүүдийг санхүүгийн тайлангийн Тодруулга 2 болон 4-д тус тус толилуулсан.	- Түүхэн ТТБМ, АҮМ-ийг тодорхойлох тооцоололд ашигласан дотоод болон гадаад эх сурвалжийн мэдээллүүдийн зөв зохистой байдлыг санамсаргүй түүврийн аргаар шалгасан; - Макро эдийн засгийн хэмжүүрүүдийг боломжит гадаад эх сурвалжийн мэдээллүүдтэй тулгасан; - ЧӨД болон зээлийн хөрвүүлэлтийн коэффициентүүдийн хүлээлтийн үнэн зөв байдлыг шалгасан;
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаатай хамааралтай бусад толилуулга болон зээлийн эрсдэлийн удирдлагыг санхүүгийн тайлангийн Тодруулга 6, 12 болон 21.3-д тус тус толилуулсан.	Бид ХБЗА-ын загварын гол өгөгдлүүдэд ашигласан үнэлэмжийн тууштай байдлыг авч үзсэн. Мөн бид нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудын зохистой байдлыг үнэлсэн.

Жилийн тайланд тусгагдсан бусад мэдээлэл

Захирлууд болон Гүйцэтгэх удирдлагууд бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт аудитын тайлан гарсан өдрөөс хойш гарахаар хүлээгдэж буй жилийн тайланд тусгагдах нэгтгэсэн санхүүгийн тайлангууд болон тэдгээрт хамаарах аудиторын тайлангаас бусад мэдээлэл ("Бусад хэсэг") багтана.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд тэдгээрт аливаа хэлбэрийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын аудиттай холбоотой бидний хүлээх хариуцлага нь бусад мэдээллийг уншиж, тэдгээр нь нэгтгэсэн санхүүгийн тайлангууд эсхүл аудитын явцад бидний олж авсан мэдээллээс материаллаг байдлаар зөрүүтэй эсхүл алдаатай эсэхийг харгалзаж үзэх явдал юм.

Жилийн тайлангийн "Бусад хэсэг"-ийг унших үед тэнд материаллаг буруу илэрхийлэл байна гэж дүгнэвэл уг асуудлын талаар бид засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгдэх шаардлагатай байдаг.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, бодитойгоор илэрхийлэх ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг дүнг буруу илэрхийлэлгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.



Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (Үргэлжлэл)

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага (Үргэлжлэл)

Компанийн удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Группийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсхүл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

"АОУС"-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох нэгтгэсэн санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Группийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Группийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай



Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (Үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (Үргэлжлэл)

болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Группийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.

- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь бодитой илэрхийлэгдэх шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.
- Нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт гаргахын тулд Группд хамаарах хуулийн этгээдүүд болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлд холбогдох хангалттай, зохистой аудитын нотолгоог цуглуулах болон группийн аудитын төлөвлөлт, удирдлага, хяналт болон аудитын ажиллагааг гүйцэтгэх бүрэн хариуцлагыг хүлээдэг. Нэгтгэсэн санхүүгийн тайланд гаргасан аудиторын дүгнэлтэд бид бүрэн хариуцлага хүлээнэ.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдэд мэдэгддэг.

Мөн бид өөрсдийн хараат бус байдлыг хөндсөн ёс зүйн шаардлагуудыг хангасан тухай мэдэгдлийг засаглал хариуцсан этгээдүүдэд хүргэж, бидний хараат бус байдалд зохистойгоор хамааралтай гэж үзэж болох бүхий л харилцаа болон бусад асуудлуудын талаар болон хэрвээ шаардлагатай тохиолдолд аливаа эрсдэлийг арилгахаар авсан арга хэмжээг мэдэгддэг.

Засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгдсэн асуудлаас бид тухайн тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудлуудыг аудитын онцгойлсон асуудлууд гэж тодорхойлдог. Хууль тогтоомж нь уг асуудлуудын талаар олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсхүл тун ховор тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлуудын талаар мэдээллэх нь олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлуудыг бид аудиторын тайландаа толилуулдаг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Группийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Группийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Ernst & Young Mongolia Audit LLC

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид

Доржбатын Мандахбаяр
Партнер

Монгол улс, Улаанбаатар хот

Огноо: 2026 оны 2 дугаар сарын 6